



**“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024  
ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ,  
ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

**2025 ОН**




# “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 6,879.4 сая төгрөгөөр баталсан байна.



ОНХС-гийн өмнө оны үлдэгдэл болон бусад эх үүсвэрээс 2,974.3 сая төгрөгөөр баталсан байна.



Нийт эх үүсвэр 9,853.7 сая төгрөг

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд аймаг, сумдад нийт 114 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтыг аймаг, сумдаар харуулбал:



**СУМЫН ОНХС-ИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХИЙХДЭЭ ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ  
1,170.3 СЯЯ ТӨГРӨГИЙН 13 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ  
БАТЛУУЛСАН БАЙНА.**



**Аймгийн хэмжээнд 10 багийн  
1324 иргэнээс ОНХС-ийн  
хөрөнгөөр санхүүжүүлэх  
хөрөнгө оруулалт, төсөл арга  
хэмжээний нийт 147 саналыг  
гаргаснаас 111 төсөл арга  
хэмжээ нь батлагдсан байна.**

**ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:**

№	Нэр	Баталсан		Хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй	
		ТАХ тоо	Төсөв /сая төг/	ТАХ тоо	Төсөв /сая төг/	ТАХ тоо	Төсөв /сая төг/	ТАХ тоо	Төсөв /сая төг/
1	Аймгийн ОНХС	30	3,064.5	13	1,309.1	14	1,569.4	3	112.7
2	Сүмбэр сумын ОНХС	35	3,317.9	31	2,773.8.	2	76.8	2	321.6
3	Шивээговь сумын ОНХС	19	2,340.6	15	1,937.8	2	230.0	2	65.0
4	Баянтал сумын ОНХС	30	1,130.6	27	1,091.4			3	7.0
<b>Нийт дүн</b>		<b>114</b>	<b>9,853.6</b>	<b>86</b>	<b>7,112.1</b>	<b>18</b>	<b>1,876.2</b>	<b>10</b>	<b>506.3</b>

# ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 84.3%-Д ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕР ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

9,142.3 сая төгрөгийн 101 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн

8,643.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 91 ТАХ-ний худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, 8,283.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан

Тайлант хугацаанд гэрээ байгуулсан ТАХ-ний худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалтын төрлөөр нь дараах хүснэгтээр харуулав.

/сая төгрөгөөр/

№	ОНХС	Гэрээ байгуулсан ТАХ: Үүнээс		НТШ		ХА		ШХА		Тендер зарлаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг	26	2,864.1	6	1,664.1	8	451.9	11	648.1	1	100.0
2	Сүмбэр	30	2,570.1	8	1,726.1	10	507.1	12	336.9		
3	Шивээговь	16	1,919.6	8	1,615.2	3	181.2	5	123.2		
4	Баянтал	19	929.5	1	595.3	7	245.5	10	88.7	1	40.0
<b>Нийт дүн</b>		<b>91</b>	<b>8,283.3</b>	<b>23</b>	<b>5,600.7</b>	<b>28</b>	<b>1,385.7</b>	<b>38</b>	<b>1,156.9</b>	<b>2</b>	<b>140.0</b>

ОНХС-ийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг жижиглэн хуваасан, босго үнийг баримтлаагүй, тендер зарлалгүйгээр 140.0 сая төгрөгийн 2 ажилд шууд гэрээ байгуулсан байна.

# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	<p>ЕБС-д 1,603.4 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ</p>		<p>Дэд бүтцийн салбарт 929.0 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ</p>
	<p>СӨБ-д 334.9 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ</p>		<p>Спортын салбарт 438.7 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ</p>
	<p>ЭМ-ийн салбарт 44.1 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ</p>		<p>Соёлын салбарт 66.3 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ</p>
	<p>Шинээр хийгдсэн худаг, усны шугам хоолойн засвар 1,054.1 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ</p>		<p>Тэрбум мод хөтөлбөрт 337.0 сая төгрөг 4 төсөл арга хэмжээ</p>

## ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

<p><b>75.4 %</b></p>	<p>ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтот үр дүн 75.4 хувьтай байна</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тайлант онд хэрэгжилт дутуу 15.8% буюу 18 төсөл, арга хэмжээ</li> <li>- Огт хэрэгжээгүй 8.8% буюу 10 төсөл, арга хэмжээ</li> </ul>
----------------------	--



# АУДИТЫН ДҮГНЭЛТ, ШИЙДВЭРИЙН МЭДЭЭЛЭЛ

**АУДИТААР НИЙТ 1,949.0 САЯ ТӨГРӨГИЙН 25 ЗӨРЧИЛ ИЛЭРСЭН.**



**АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ АРИЛГУУЛАХААР ХҮРГҮҮЛСЭН  
АУДИТЫН ШИЙДВЭРИЙН МЭДЭЭЛЭЛ**

Албан шаардлага	Төлбөрийн акт	Зөвлөмж
 <p>6 байгууллагад 1,947.8 сая төгрөгийн 19 зөрчлийг арилгуулах албан шаардлага</p>	 <p>1.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт</p>	 <p>Аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байр 5 зөвлөмж</p>



# АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

## Аймгийн, сумдын ИТХ-ын даргад:

1. ОНХС-гаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хянах, гүйцэтгэлийн хяналтаар илэрч байгаа зөрчлийг таслан зогсоох зөвлөмж, дүгнэлт гаргаж, нотлох баримтаар дэмжигдэхүйц хяналтын тайланг гаргаж холбогдох байгууллага албан тушаалтанд албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг тооцдог байх

## Аймаг, сумдын Засаг дарга нарт :

1. ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадмын зардлыг төлөвлөхдөө Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолыг баримтлах

2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс зорилтот үр дүндээ хүрээгүй ажлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, тайлант онд төлөвлөсөн үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг мөрдөж ажилладаггүй үнэлгээний хорооны дарга, гишүүдийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хороодод үүрэг болгох

## Сумдын Засаг дарга нарт:

1. Сумдын тендер шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа ерөнхий гэрээнд заагдсан 100.0 сая дээш худалдан авалтад гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардах

2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагын данс бүртгэлд хүлээлгэн өгсөн хөрөнгө, хийгдсэн ажлын тоо хэмжээгээр нэг бүрчлэн задалж бүртгүүлэх, бүртгэлд хяналт хэрэгжүүлэх

**WWW.AUDIT.MN ЦАХИМ ХУУДСАНД ХАНДАЖ АУДИТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАНА УУ**